210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,907.38
210803	Даатгалын үйлчилгээ	59.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,559.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,559.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,433.44</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,433.44</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,433.44
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>71,005.35</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>71,005.35</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,005.35

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Ганбүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг гүйцэтгэв.

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын азарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/85 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын эрхэм зорилго, зорилт**

Улаанбадрах сум нь эрхэм зорилгоо “Хүний хөгжил, өв соёлоо дээдэлж, ирээдүйдээ үлдээх баялагтай, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах” гэж тодорхойлсон байна.

Тайлант 2020 онд “Хүний хөгжлийг дэмжих” зорилт дэвшүүлж ажилласан байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус сумын санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд дотоод хяналт хийгдээгүй байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны батлагдсан төсөв болох 2,327.6 сая төгрөгийн 1 хувь буюу 23.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсөв /2020 оны 12 дугаар сард тодотгосон төсөв/ болох 2,384.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцож, 23.8 сая төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 105.4 сая, эцсийн үлдэгдэл 277.8 сая төгрөг болж, 172.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	105.4	277.8	172.4	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>246.7</b>	<b>314.6</b>	<b>67.9</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 277.8 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 131.9 сая, эцсийн үлдэгдэл 255.8 сая төгрөг болж, 123.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	81.6	81.6
Төлбөртэй үйлчилгээний авлага			-
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	-	0.2	0.2
Бусад авлага			
Зээлийн авлага	131.9	174.0	42.1
<b>Дүн</b>	<b>131.9</b>	<b>255.8</b>	<b>123.9</b>

*Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд 2-3 жилийн насжилттай 99.5 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл болох 99.5 сая төгрөгийн авлага,

Хугацаа хэтэрсэн зээлийн авлага болон олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 16 зээлдэгчийн 167.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Уг зөрчлийг ТТЗ-ын аудитын явцад арилгаж, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан болно.

- Тус сумын хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 13.9 сая төгрөгийн авлагатай ажиллаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл байхгүй ба эцсийн үлдэгдэл 148.3 сая төгрөг болж, 148.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	148.3	148.3
Цалингийн урьдчилгаа	-	-	-
Томилолтын урьдчилгаа	-	-	-
<b>Дүн</b>		<b>148.3</b>	<b>148.3</b>

*Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд үүссэн, ОНХС-ийн хөрөнгөөр баригдаж байгаа ТАХ-ны санхүүжилт байна.

### 3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 275.7 сая, эцсийн үлдэгдэл 277.8 сая төгрөг болж, 2.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	64.8	70.3	5.5
Эм боох материал	9.6	20.3	10.7
Бичиг хэргийн материал	8.1	8.6	0.5
Аж ахуйн материал	46.0	41.1	-4.9
Сэлбэг хэргэсэл	0.8	0.5	-0.3
Түлш шатах тослох материал	31.9	16.4	-15.5
Хүнсний материал	12.0	5.2	-6.8
Бусад хангамжийн материал	97.8	110.5	12.7
Мал амьтад	4.7	4.9	0.2
<b>Дүн</b>	<b>275.7</b>	<b>277.8</b>	<b>2.1</b>

*Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч нөөцөлсөн, мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

-Тус сумын ЗДТГ нь түлш, шатахууныг харьцуулалтын аргаар худалдан авах байтал шууд худалдан авалт хийж, холбогдох хууль, журмыг зөрчсөн байна.

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,405.8 сая, эцсийн үлдэгдэл 4,667.8 сая төгрөг болж, 262.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,109.70	3,058.90	50.80
Авто-тээврийн хэрэгсэл	108.90	217.30	(108.40)
Машин тоног төхөөрөмж	147.50	193.40	(45.90)

Тавилга эд хогшил	47.20	77.60	(30.40)
Түүх соёлын дурсгалт зүйлс	2.50	2.50	-
Бусад үндсэн хөрөнгө	811.00	983.20	(172.20)
Дуусаагүй барилга байгууламж	50.00	-	50.00
Ном	28.60	28.60	-
Программ хангамж	0.30	4.70	(4.40)
Бусад биет бус хөрөнгө	100.10	101.60	(1.50)
<b>Дүн</b>	<b>4,405.8</b>	<b>4,667.8</b>	<b>(262.0)</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 66.3 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 393.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба балансаас балансад шилжүүлсэн 50.0 сая, акталсан 34.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Тус сумын Засаг даргын тамгын газарт элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 250.8 сая төгрөгийн, 220 ширхэг үндсэн хөрөнгө ашиглаж байна.

-Мөн дээрх байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 60 ширхэг 562.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тооцож өгөөгүйгээс элэгдэл тооцоогүй байна.

-Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд 0.7 сая төгрөгийн элэгдэл тооцоогүй үндсэн хөрөнгө байна.

#### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.08 сая, эцсийн үлдэгдэл 0.7 сая төгрөг болж, 0.62 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	0.08	0.7	0.62	
Байгууллагат төлөх өглөг	0.08	-	-0.08	
Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	0.7	0.7	100
<b>Нийт дүн</b>	<b>0.08</b>	<b>0.7</b>	<b>0.62</b>	<b>100</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дүнд хувь хүний орлогын албан татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн ба энэ нь төсвийн хүрэлцээгүйн улмаас үүссэн байна.

#### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,918.9 сая, эцсийн үлдэгдэл 5,626.8 сая төгрөг болж, 707.9 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал -Засгийн газрын сан, орон нутгийн сан	2,123.0	2,123.0	-	37.7
Хуримтлагдсан үр дүн	1,172.0	1,879.9	707.9	33.4

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,623.9	1,623.9	-	28.9
<b>Дүн</b>	<b>4,918.9</b>	<b>5,626.8</b>	<b>707.9</b>	<b>100</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,626.8 сая төгрөг болж 707.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үүнд:

- Хуримтлагдсан үр дүн 1,879.9 сая төгрөг болж 707.9 сая төгрөгөөр өссөн нь нэгтгэлд хамрагдсан 10 байгууллагаас 9 байгууллага нь ашигтай ажилласнаас шалтгаалжээ.

### 3.5.8 Орлогын данс

Тайлант онд нийт 2,683.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнд, татварын орлого 50.0 сая төгрөг, татварын бус орлого 424.7 сая төгрөг, үндсэн болон нэмэлт санхүүжилтийн орлого 2,208.9 сая төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Татварын 8 төрлийн орлогыг бүрдүүлж ажилласан байна. Татварын бус орлогод хүү, торгуулийн орлогоос 0.07 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 8.8 сая төгрөг, зээлийн хүүгийн орлогоос 3.4 сая төгрөгийг бүрдүүлсэн ба үнэ төлбөргүй 393.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 18.7 сая төгрөгийн бараа материалыг орлогод тусгасан байна.

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 982.3 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлгээр 598.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс урсгал санхүүжилтэд 470.1 сая төгрөг, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардалд 72.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагын урсгал зардалд 15.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр урсгал зардалд 71.0 сая төгрөг, нийт 2,208.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

### 3.5.9 Зардлын данс

Тайлант онд нийт 1,982.0 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд, үйл ажиллагааны зардлын дүн 1,912.4 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардлын дүн 69.6 сая төгрөг байна. Нийт зардалд материаллаг хэмжээний цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал /59.0 хувь/, хангамж бараа материалын зардал /17.0 хувь/ байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Тус сумын ЗДТГ нь 4.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын холбогдох заалтыг зөрчсөн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 12/09 дугаар тогтоолд зааснаар Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 34.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 50.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 47.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого, /сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	2.15	3.26	(1.11)	152%
2	Хадгаламжийн хүүгийн орлого	17.12	15.75	1.37	92%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	9.20	20.71	(11.51)	225%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	0.05	1.20	(1.15)	2400%
5	Галт зэвсгийн албан татвар	2.31	1.98	0.33	86%
6	Улсын тэмдэгтийн хураамж	0.50	1.59	(1.09)	319%
7	Хог хаягдлын хураамж	2.50	1.61	0.89	64%
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.05	3.90	(3.85)	7808%
9	Хүү торгуулийн орлого	0.15	0.07	0.08	47%
10	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4.00	4.10	(0.10)	103%
	<b>НИЙТ</b>	<b>38.03</b>	<b>54.17</b>	<b>(16.14)</b>	<b>142%</b>

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 6 нэр төрлийн орлого 18.8 сая төгрөгөөр давж, 4 нэр төрлийн орлого 2.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд,

- Үйл ажиллагааны орлого 1.1 сая төгрөгөөр давсан нь 2019 онд ногдуулсан татварыг тайлант онд төвлөрүүлсэн,
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 11.5 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгөөнд тусгагдаагүй, эх орны хишиг, ноос, арьс ширний урамшууллаас татвар суутгасан,
- Хөрөнгө борлуулсны орлого 1.1 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгөөнд тусгагдаагүй, зарим иргэд орон сууц борлуулсан,
- Улсын тэмдэгтийн хураамж 1.1 сая төгрөгөөр давсан нь гарын үсгийн баталгааг нотариатаар батлуулсан,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3.8 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгөөнд тусгагдаагүй, Борхойн зам ХХК-ийн ашигласан ашигт малтмалын төлбөр болно.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд,

- Хадгаламжийн хүүгийн орлого 1.4 сая төгрөгөөр тасарсан нь Төрийн банк 2020 оноос хадгаламжийн хүүг аймгийн Төрийн банканд төвлөрүүлж, хүүг сумын Төрийн санд шилжүүлдэггүй болсонтой холбоотой.
- Галт зэвсгийн албан татвар 0.3 сая төгрөгөөр тасарсан нь 2 иргэн буюу шилжүүлсэн, татвараа төлөөгүй 3 иргэн холбоо барих боломжгүй байсан зэргээс шалтгаалсан байна.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.9 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөгөөнд тусгагдсан, “Бадрах энерги” ХХК үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

**Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлээгүй байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөр, 19 арга хэмжээнд зориулан 2,384.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,786.0 сая төгрөгийг урсгал зардалд, 598.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,593.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 626.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 149.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,580.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 576.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 15.0 сая төгрөгийг, нийт 2,171.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 63.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 72.8 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 76.2 сая төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн орлого 72.5 сая, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх орлого 3.8 сая төгрөгөөр тасарснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,055.3 сая төгрөг буюу 86.2 хувьтай /328.7 сая төгрөгийн хэмнэлттэй/ байгаа нь урсгал санхүүжилтийг 63.1 сая төгрөгөөр дутуу олгосон, сум хөгжүүлэх сангийн 39.9 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн тусгай дансыг төлөвлөсөн дүнгээс 5.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгийг 189.9 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 34.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь ЗДТГ-т 1 орон тоо 2020 онд сул байснаас шалтгаалсан, мөн сургууль, цэцэрлэгт цалингийн зардал /цар тахлын улмаас хичээллээгүй учир илүү цагийн нэмэгдэл хэмнэгдсэн/ хэмнэгдэж татварын байгууллагад шилжүүлсэн ба НДШ нь хэмнэгдэн төсөвт үлдсэн байна.
- Түлш халаалтын зардлыг 21.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь соёлын төвийн шинэ барилгыг 2020 онд ашиглалтад орох тооцоололтойгоор түлш халаалтыг тооцсон боловч 2020 оны жилийн эцэст ашиглалтад орсон нь түлш халаалтын зардлыг 5.4 сая төгрөгөөр, эрүүл мэндийн төв, цэцэрлэгийн түлш халаалтын зардлыг тус суманд төвлөрсөн дулаанаар хангахаар төсвийг тооцсон боловч, тайлант оны 10 дугаар сард төвлөрсөн халаалтад холбогдсон байна. Нүүрс худалдан авах зардал нь төвлөрсөн халаалтад холбогдох зардлаас бага байдаг байна.
- Хоол, хүнсний зардлыг 21.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь цар тахлын улмаас хүүхдийн цэцэрлэг болон сургуулийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна. Тухайлбал, сургуулийн хоол, хүнсний зардал 7.4 сая төгрөгөөр, цэцэрлэгийн хоолны зардал 14.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 44.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн ба энэ нь сум хөгжүүлэх сангаас тайлант онд 140.0 сая төгрөгийн зээл олгох, бусад зардал гаргахаар сумын ИТХ-аар батлагдсан боловч гүйцэтгэлээр 100.1 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж, 39.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн, мөн нөхөн сэргээлтийн тусгай данснаас 5.0 сая төгрөгийг зарцуулах төлөвлөгөөтэй байсан боловч, тайлант онд нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 30.2 сая төгрөгийг улсын, 0.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 598.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гэрээ байгуулан 559.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Тендерийн хэмнэлт 38.8 сая төгрөг байна. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д санхүүжилтийг бүрэн олгосон ба үүнээс тайлант 262.7 сая төгрөгийн онд 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн, 259.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, 296.5 сая төгрөгийн 1 арга хэмжээнд бүрэн хэрэгжээгүй ба ажлын гүйцэтгэлд үндэслэн 148.3 сая төгрөгийг дутуу олгосон байна. Бүрэн хэрэгжээгүй ажлын үлдэгдэл санхүүжилт болох 148.3 сая төгрөг, дутуу олгосон санхүүжилт 2.9 сая төгрөгийг, тендерийн хэмнэлт болох 38.8 сая төгрөг, нийт 190.0 сая төгрөг тайлант оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэмж бүртгэгдсэн байна.

## **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 68.0 сая, нийт 71.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардал 6.5 сая, нормативт зардалд 22.2 сая, багаж, техник, хэрэгслийн зардалд 26.6 сая, томилолтын зардалд 0.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3.0 сая, бараа ажил үйлчилгээний зардалд 1.6 сая төгрөг, нийт 60.6 зарцуулж, үлдэгдэл 10.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 150 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

### **3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлэн байгууллага аудитад хамрагдаагүй байна. Сургуулийн ахмадын сан болон нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ болон холбогдох ТШЗ-ын санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 3 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба зөрчилтэй дүгнэлт авсан байгууллага үгүй болно.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй ба залруулга хийгдээгүй, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 248.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 75.4 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 172.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлжээ.

Сум хөгжүүлэх сангийн 16 зээлдэгчтэй авлагын тооцоо нийлээгүй 167.6 сая төгрөгийн зөрчилд тус сангийн аудитыг гүйцэтгэх явцад албан шаардлага хүргүүлсэн. Уг зөрчлийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад арилгасан учир ТТЗ-ын аудитын тайланд зөрчилд тооцсон боловч, аудитын явцад залруулсан учир дүгнэлт гаргахад зөрчлийн дүнд нөлөөлөхгүй гэж үзлээ.

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тайлант оны төсвийн төслийг боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлэх ажил хийгдээгүй байна. Иймд төсвийн төсөл, тухайлбал, сумын татварын ба татварын бус орлогын тооцоолол, үндэслэл бүхий төслийг боловсруулж байх шаардлагатай байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2020 он

Аудитын нэр:

Улаанбадрах сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мянган төгрөгөөр

Аудитын код:

ДГА-2021/16/СТА-ТТЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Улаанбадрах сумын төсвийн төвлөрүүлэн захирагч

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
А		1	2	3			4	5
1	Улаанбадрах сумын ЗДТГ	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	4,409.4	Албан шаардлага өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	ЗДТГ-ын дарга	М.Хишигбаяр
2		Тээвэр шатахууны зардалд харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр шууд худалдан авалт хийсэн /Завсрын аудит/	-	Зөвлөмж өгөх				
3		Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн 220 ширхэг 250.8 сая төгрөгийн хөрөнгө ашиглагдаж байна. /Завсрын аудит/	-	Зөвлөмж өгөх				
4		4 нэр төрлийн 60 ширхэг 562.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тооцож өгөөгүйгээс элэгдэл тооцоогүй байна. /Завсрын аудит/	-	Зөвлөмж өгөх				
5		Сумын Засаг даргын шагналын журмыг батлаагүй байна /Завсрын аудит/	-	Зөвлөмж өгөх				
6		Эд хариуцагчийн түлш шатахууны тайлангийн үлдэгдэл НББ-ээс зөрүүтэй илэрхийлэгдсэн	327.7	Аудитын явцад залруулсан				
7		Цалин хөлс, НДШ-ийн зардал ҮДТ-нд МГТ-аас зөрүүтэй илэрхийлэгдсэн	10,222.7	Аудитын явцад залруулсан				
8		Түлш халаалтын зардалд бичиг хэргийн зардлыг хаасан /12.8 мян.төг/, даатгалын зардал дутуу илэрхийлэгдсэн /102.2 мян.төг/, принтерийн хор шууд зардалд бичсэн /35.0 мянган төгрөг/, дугуй худалдаж авсан татварын 10 хувь 39.6 мянган төгрөгийг БҮТЭЗ-ийн зардалд бичсэн	189.6	Аудитын явцад залруулсан				
9		Төсвийн гүйцэтгэлийн тайланд 275.5 мянган төгрөгийн зарлагыг буруу тайлагнасан байна	275.5	Аудитын явцад залруулсан				
10	СХС	2020.12.31-ний байдлаар нийт 16 зээлдэгчийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	167,645.1	Албан шаардлага өгөх	Хэсэгчлэн аудит хийх		Засаг дарга, нягтлан бодогч	Г.Ганбүрэн, Б.Оюунцэцэг
11		Зээлийн хүү болон алдангийн орлогыг буруу тооцоолсон байна.	7,197.4	Аудитын явцад залруулсан				
12		Зээлийн авлагын тооцоолол алдаатай тул санхүүгийн тайланд буруу тайлагнасан байна.	7,197.4	Аудитын явцад залруулсан				
13	Улаанбадрах сумын цэцэрлэг	Элэгдлийн тооцооллыг давтан шалгахад зарим хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	734.9	Зөвлөмж өгөх	Хэсэгчлэн аудит хийх		Нягтлан бодогч	Б.Уранбилэг
14		Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, холбогдох тушаал шийдвэрийг ирүүлээгүй тул горим сорилыг хэрэгжүүлэх боломжгүй	-	Зөвлөмж өгөх				

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
15	Улаанбадрах сумын сургууль	Тайлант хугацааны эцэст авлагын үлдэгдэлтэй ажилласан	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Захирал	Н.Намжилсүрэн
16	Улаанбадрах сумын өрхийн эрүүл мэндийн төв	Иргэд, ААН байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е-баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхцацрал, Х.Солонго
17	Улаанбадрах сумын соёлын төв	Алдаа, зөрчил илрээгүй			Хэсэгчлэн аудит хийх			
18	Улаанбадрах сумын ОНХС	Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг шилжүүлэхдээ зардлыг буруу дансанд бүртгэсэн	50,000.0	Аудитын явцад залруулсан	Хэсэгчлэн аудит хийх			
19	Улаанбадрах сумын ИТХ	Итгэл үзүүлсэн	-		Итгэл үзүүлсэн			
		<b>НИЙТ</b>	<b>248,199.7</b>					